

**“ЭН БИ СИ” ХХК-ИЙН ОЛОН СУВАГ ДАМЖУУЛАХ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СҮЛЖЭЭНД ХОЛБОГДОХ НӨХЦӨЛ /РАО/**

Энэхүү баримт бичгээр Телевизийн үйлчилгээ эрхлэгчтэй байгуулах Холболтын гэрээний нөхцөлийг тодорхойлсон ба Харилцаа холбооны зохицуулах хороо (цаашид “Зохицуулах хороо” гэх)-ны 2021 оны 33 тоот тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Сүлжээ хооронд харилцан холболт хийх, сүлжээнд холбогдох гэрээний ерөнхий нөхцөл, орлого хуваарилах журам” (цаашид “Холболтын журам” гэх)-ын 2.5 дах хэсэгт заасныг баримтлан боловсруулсан болно.

“ЭН БИ СИ” ХХК нь олон суваг дамжуулах DVB-T2 үйлчилгээг ... тоот тусгай зөвшөөрөлтэйгээр Улаанбаатар хотод хүргэдэг.

1. Сүлжээнд холбогдох технологийн стандарт, горим, нөхцөл шаардлага

Телевизийн студиас өгөх дохио нь дараах стандарт, үзүүлэлтийг хангана.

ИНТЕРФЕЙС	
Дүрсийн оролт (PAL)	[SD форматаар дамжуулах бол SMPTE 259M-C (SD-SDI), ITU-R BT601 стандартыг хангасан байх.]
	[HD форматаар дамжуулах бол SMPTE 292M (HD-SDI), ITU-R BT709 стандартыг хангасан байх.]
Дууны оролт	[Embedded audio (Дүрсний сигналд нь суулгасан аудио сигнал)]
ДҮРСИЙН ҮЗҮҮЛЭЛТ	
Дэлгэцийн харьцаа	[4:3, 16:9]
SD нягтрал /пикселийн тоо/	[SD-SDI 625@50i гэх мэт]
HD нягтрал /пикселийн тоо/	[HD-SDI, 1080@50i, шахалтын стандарт нь MPEG/AVC (H.264) гэх мэт]
ДУУНЫ ҮЗҮҮЛЭЛТ	
Дууны түвшин	[Монгол Улсын “Тоон телевизийн студи. 2-р хэсэг: Тоног төхөөрөмжид тавих ерөнхий шаардлага” MNS 5592-2:2016 стандартад заасны дагуу дууны гаралтын түвшин -18dBFS, эгшин зуурын утга нь ±1 байна.]
Дууны кодлол	[Стерео болон MPEG layer 1, 2, 3 , AAC, AES гэх мэт]

2. Зааглах цэгийн байршил, ашиглалт үйлчилгээ

2.1 Сүлжээнд холбогдох зааглах цэгийн боломжит байршлуудыг дараах хүснэгтэд харуулав.

Зааглах цэг байрлах хаяг (Боломжит зааглах цэгүүдийн байршил)	
Байршил 1:	Телевиз нь MNBC-ийн сүлжээний шилэн кабелийг ашиглан эфирээ дамжуулах тохиолдолд зааглах цэг телевизийн байран дахь нэвтрүүлэх төхөөрөмжийн гаралт дээр байрлана.
Байршил 2:	Телевиз нь өөрсдийн шилэн кабелийг ашиглан эфирээ MNBC-ийн толгой станцын оролтонд холбогдож, дамжуулах тохиолдолд зааглах цэг ЭнБиСи ХХК-ийн байранд байрлана.

Байршил 3:

Телевиз нь дундын холбох цэгээр дайран MNBC толгой станцын оролтонд холбогдох үед зааглах цэг нь дундын холбох цэгийн байранд байрлана.

- 2.2 Телевизийн үйлчилгээ эрхлэгч нь өөрийн студиэс зааглах цэг хүртэлх сүлжээг (сүлжээ түрээслэх, татах, ашиглалт үйлчилгээ зэрэг) хариуцна.
- 2.3 Телевизийн үйлчилгээ эрхлэгч нь зааглах цэгийг дээр зааснаас өөр цэгт тогтоох саналтай бол хүсэлтийг албан бичигтээ тодорхой дурдаж, техникийн нөхцөл байдлын талаарх мэдээллийг ирүүлнэ. Хэрвээ тус зааглах цэг нь Зохицуулах хорооноос баталсан Холболтын журмын Хавсралт 4-д зааснаас өөр газарт байрлах бол албан бичгийн хувийг Зохицуулах хороонд илгээж, шийдвэрлүүлнэ.
- 2.4 Тоног төхөөрөмжийн мэдээлэл:

ХОЛБОЛТ ХИЙХ ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Үзүүлэлт	ТВ суваг	ЭН БИ СИ
Холболтын төхөөрөмжийн төрөл, марк	Playout server	Encoder
Инкодер /хөрвүүлэх төхөөрөмж/ -ийн төрөл, марк	3G /HD/SD – SDI fiber Transmitter	3G/HD/SD- SDI fiber receiver
Гаралтын формат	I core fiber optic cable	I core fiber optical
Интерфейсийн төрөл	3G /HD/ SD- SDI	3G/HD/SD-SDI


- 2.5 Телевиз өөрийн хөрөнгөөр дамжуулагчийн шаардлагад нийцсэн transmitter, receiver-г ханган ажиллаж, анхны холболтын төлбөрөөс transmitter, receiver-н дүнг хасаж тооцоо нийлэх боломжтой.

Техникийн үзүүлэлт, холболтын стандартыг дамжуулагч тал тухай бүр тодорхойлно.


ТВ суваг нь Телевизийн студи-Тоног төхөөрөмжид тавих ерөнхий шаардлага MNS 5592-2:2016 стандартыг дагаж мөрдөнө.

- 2.6 ТВ СУВАГ БОЛОН ЭН БИ СИ СҮЛЖЭЭ ХООРОНДЫН ХОЛБОЛТЫН СХЕМ, ЗУРАГЛАЛ

2.6.1 Телевиз нь MNBC-ийн кабелиар шууд холбогдох үед зааглах цэгийн байрлал



2.6.2 Телевиз нь өөрөө MNBC толгой станцын оролтонд холбогдох үеийн Зааглах цэг



2.6.3 Телевиз нь дундын холбох цэгээр дайран MNBC толгой станцын оролтонд холбогдох үеийн Зааглах цэг



3. Гэрээ хийх үйл ажиллагааны нарийвчилсэн мэдээлэл

**ХАРИЛЦАН МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ АЛБАН ТУШААЛТАН,
ТЭДГЭЭРИЙН НЭРС, ХОЛБОО БАРИХ АРГА ХЭРЭГСЭЛ**

	Алба, хэлтэс	Овог нэр Албан тушаалтан	Холбоо барих хэрэгсэл
Гэрээний асуудлаар	БТГазар	Захирал Г.Гарьдхүү	99054045
	ҮАХГазрын	Захирал Ж.Золбат	88109500
Техникийн асуудлаар	МТТГазар	МТТГ захирал Д.Оюунгэрэл	Утас: 89114805 И-мэйл: oyungerel@mnbctv.mn
		Инженер Н.Мягмарсүрэн	Утас: 99784345 И-мэйл: MNBC_epg@yahoo.com
Төлбөр тооцооны асуудлаар	Санхүү бүртгэлийн газар	Тооцооны нягтлан бодогч Б.Алтанноров	Утас: 80079907 И-мэйл: altannorov@mnbctv.mn
		Төлбөр тооцоо хариуцсан ажилтан	Утас: И-мэйл:

4. Сүлжээнд холбогдох төлбөр тооцооны мэдээлэл

4.1 Дамжуулагч тал нь телевизийн эфирийг өөрийн шилэн кабелиар дамжуулан авсан нөхцөлд шилэн кабелийн ашиглалтын урсгал зардлыг тухайн ТВ-ийн байршлаас хамааруулан тооцож үзсэний үндсэн дээр дамжуулалтын төлбөр тооцоог тогтоож тухайн телевизээс сар бүр нэхэмжлэн авна. Тухайн ТВ нь өөрийн кабелиар дамжуулагчийн толгой станцын оролтонд эфирийн сигналаа өгсөн нөхцөлд дамжуулалтын төлбөр тооцохгүй.

Сувгийн үйл ажиллагаа явуулж байгаа байршил, хамрах хүрээ	Суваг холбох холболтын хураамж (Анх холбогдоход нэг удаа)	
Улаанбаатар хотод (HD, SD хамаарахгүй)	Тоног төхөөрөмж (Шилэн кабелийн нэвтрүүлэгч, хүлээн авагч, бусад төхөөрөмж)	(₮)
	Хяналт (Monitoring, Server, Display, Data center)	
	Шилэн кабель (Зааглах цэгээс MNBC толгой станц хүртэл шилэн кабелийн бүх холболт)	

Дээрх үнэд НОАТ орсон болно.

4.2 Телевизийн суваг дамжуулах сарын хураамжийн задаргаа /сар бүр/

Зардлын төрөл	Зааглах цэгийн байршил	
	1 ба 3-р нөхцөл	2-р нөхцөл
Шилэн кабель эсвэл урсгал түрээсийн төлбөр₮₮

ЭН БИ СИ ХХК БОЛОН “ЭН”-ИЙН ХООРОНДЫН ХАРИЛЦАН ХОЛБОЛТЫН ГЭРЭЭ

2022 оны-р сарын

№.....

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг: Нэг талаас Сүхбаатар дүүрэг, 10 хороо, Цагдаагийн гудамж, өөрийн байр хаягт байрлах, Монгол улсын хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 9011355043 дугаарын гэрчилгээтэй, регистрийн 2873524 дугаартай **ЭН БИ СИ ХХК** /цаашид “Дамжуулагч” гэх/, түүнийг төлөөлж Бизнес төлөвлөлтийн газрын захирал Г.Гарьдхүү, Нөгөө талаас Хан-уул дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө, Капитал хаус, 5 давхар хаягт байрлах, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн..... дугаарын гэрчилгээтэй, регистрийн дугаартай /цаашид “ТВ суваг” гэх/ түүнийг төлөөлж нар /хамтад нь “Талууд”, давгаар нь зарим тохиолдолд “Тал” гэх/ Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, Харилцаа холбооны тухай Монгол Улсын хууль, Харилцаа холбооны зохицуулах хороо (цаашид ХХЗХ гэх)-ноос батлагдан гарсан холболтын талаархи холбогдох журмууд болон тус тусын байгууллагын дүрэмд үндэслэж дараах нөхцөлийг хэлэлцэн тохиролцож, харилцан зөвшөөрснөөр байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү гэрээгээр дамжуулагч нь MNBC сүлжээгээр /DVB-T2 стандарт буюу газрын дамжуулалтын сүлжээ/ Улаанбаатар хотын айл өрх, албан байгууллагад телевизийн сигналыг SD/HD форматаар чанарын өндөр төвшинд хэрэглэгчдэд хүргэх, ТВ суваг нь ашиглалт үйлчилгээний зардлыг төлөх болон талуудын эдлэх эрх, хүлээх үүргийг түүнтэй холбогдон үүсэх бусад харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. ТВ сувгийн хөтөлбөрийг дамжуулахтай холбоотой харилцааг Хавсралт 5-д заасан нөхцөлөөр зохицуулна.
- 1.3. Талууд холболт хийхдээ ямар нэгэн ялгаваргүй буюу ижил нөхцлөөр хандах, ил тод, харилцан ашигтай байх, өрсөлдөөний эсрэг шударга бус аливаа үйлдэл гаргахгүй байх зарчмуудыг баримтална.
- 1.4. Талууд ХХЗХ-оос баталсан “Сүлжээ хооронд харилцан холболт хийх, сүлжээнд холбогдох гэрээний ерөнхий нөхцөл, орлого хуваарилах журам”-ыг мөрдлөг болгон ажиллана.
- 1.5. ТВ суваг эрхлэгч нь хөтөлбөрийн дагуу бэлтгэсэн хөдөлгөөнт дүрс, график, үг, дуутай агуулгыг дамжуулагчийн стандартыг ашиглан нэвтрүүлнэ.
- 1.6. Суваг дамжуулах үйлчилгээ үзүүлэх хугацаа нь **2022** оны -р сарын..... -ний өдрөөс эхлэн оны..... -р сарын-ны өдрийг дуустал **2 /хоёр/ жилийн** хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 1.1. Гэрээний хугацаа дуусахаас 30-аас доошгүй хоногийн өмнө талуудаас гэрээ цуцлах талаар ямар нэг санал гаргаагүй тохиолдолд энэхүү гэрээг мөн нөхцөлөөр, дахин сунгагдсанд тооцно. Автоматаар сунгагдах хугацаа 1 жил байна.
- 1.2. ТВ суваг эрхлэгч нь Аж ахуй нэгжийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, гэрчилгээнд тусгагдсан иргэний үнэмлэх болон телевизийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрлийн эрхийн гэрчилгээний хуулбарыг дамжуулагчид өгч гэрээнд хавсаргана.
- 1.7. Сувгийн нэр:
- 1.8. Хамрах хүрээ: **Монгол улс**
- 1.9. Сувгийн дугаар:.....
- 1.10. Энэхүү гэрээ нь дараах хавсралтуудтай байх ба хавсралтууд нь гэрээний салшгүй хэсэг байна.
 - 1.10.1. Хавсралт №1. Техник төхөөрөмжийн үзүүлэлт
 - 1.10.2. Хавсралт №2. Холболтын зааглах цэг, зураглал
 - 1.10.3. Хавсралт №3. Мэдээлэл солилцох албан тушаалтан, тэдгээрийн хаяг, холбоо барих арга
 - 1.10.4. Хавсралт №4. Шилэн кабелин холболт, ашиглалтын төлбөр тооцоо эдгээр болно.
 - 1.10.5. Хавсралт №5 Хөтөлбөр дамжуулах нөхцөл
 - 1.10.6. Хавсралт №6 Хөтөлбөр бичих хүснэгтийн загвар

1.10.7. Хавсралт №7 NTV телевизийн үнийн санал

ХОЁР. ТАЛУУДЫН НИЙТЛЭГ ЭРХ, ҮҮРЭГ

- 2.1. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг эсвэл зохих ёсоор буюу шударгаар биелүүлэхийг нөгөө талаас шаардах
- 2.2. Гэрээнд заасан нөхцөлийн дагуу гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, гэрээний хугацааг сунгах, гэрээнээс татгалзах, цуцлах, дуусгавар болгох тухай санал гаргах;
- 2.3. Энэхүү гэрээнд заасан үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй тохиолдолд энэ гэрээний 9.6-д заасан алданги, хариуцлагын арга хэмжээг шат дараатайгаар хэрэглэх;
- 2.4. Сүлжээний найдвартай, тасралтгүй ажиллагаа, аюулгүй байдлыг бүрэн хангахыг шаардах эрхтэй;
- 2.5. Шаардлагатай нөхцөлд холбогдох баримтуудыг гаргуулан авах;
- 2.6. Гэрээний явцад харилцан хяналт тавих, зөрчил дутагдлыг хугацаа тогтоон засахыг шаардах.
- 2.7. Өөрийн сүлжээний найдвартай байдлыг хангаж, гадны халдлагаас хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллах;
- 2.8. Нөгөө тал буруутай нь тогтоогдвол өөрт учирсан хохирлоо арилгуулахыг шаардах;
- 2.9. Гэрээнд заасан нөхцөлийн дагуу тв суваг нь холболтын зардлыг төлөх;
- 2.10. Өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас нөгөө талд учруулсан хохирлыг тогтоосон хугацаанд нь нөхөн төлөх;
- 2.11. Гэрээнээс үүдэлтэй маргаантай асуудлыг зөвшилцлийн журмаар шийдвэрлэхийг эрмэлзэх;
- 2.12. Дараах нөхцөлүүдээс бусад ямар ч тохиолдолд холболтыг салгах болон хязгаарлалт хийхгүй байх;
 - 2.12.1. Давагдашгүй хүчин зүйлс тохиолдсон;
 - 2.12.2. Гэрээнд оролцогч тал цаашид үйл ажиллагаа явуулах боломжгүй болон дампуурсанаа албан ёсоор зарласан;
 - 2.12.3. Гэрээнд оролцогч тал холболтын зардлыг гэрээнд заасан төлбөр төлөх хугацаанаас 60 хоног хэтэрсэн бол холболтыг салгаж, алданги 0,5 хувиар бодож нэхэмжлэх эрхтэй байна.
 - 2.12.4. Гэрээгээр хүлээсэн техникийн үзлэг, шалгалт хийсэн тохиолдолд;
 - 2.12.5. Гэрээний үүргээ биелүүлээгүйн улмаас холболтыг салгах, хязгаарлалт хийх бол ТВ сувагт 48 цагаас багагүй хугацааны өмнө албан бичгээр мэдэгдэж өөрийн сувгийн дамжуулалтаас хязгаарлах эрхтэй байна, ХХЗХ-нд 72 цагаас багагүй хугацааны өмнө албан бичгээр тус сувгийн зөрчлийн талаар мэдэгдэх.

ГУРАВ.ТВ СУВАГ ТАЛЫН ЭРХ, ҮҮРЭГ

- 3.1. **ТВ суваг нь дор дурдсан эрх, үүргийг хүлээнэ. Үүнд:**
 - 3.1.1. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг Дамжуулагчаас шаардах эрхтэй;
 - 3.1.2. Дамжуулагч талд техникийн санал зөвлөмж өгөх эрхтэй;
 - 3.1.3. Телевизийн стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүнийг дамжуулагчийн толгой станцын оролтод шилэн кабелиар дамжуулан тасралтгүй нийлүүлэх үүрэгтэй;
 - 3.1.4. ТВ суваг тал Дамжуулагч талын шилэн кабелд холбох хүртэл техникийн шийдлийг өөрийн хүч, зардлаар шийдвэрлэнэ. Дамжуулагч талын хүсэлтээр холбогдох тоног төхөөрөмжүүдэд урьдчилан сэргийлэх үзлэг үйлчилгээ хийх үүрэгтэй;
 - 3.1.5. Техникийн гэмтэл саатал гарах, техникийн үзлэг үйлчилгээ хийх тохиолдолд ТВ суваг нь Дамжуулагч талд бололцоотой бүх хэлбэрээр урьдчилан мэдэгдэх үүрэгтэй;
 - 3.1.6. ТВ суваг тал болон Дамжуулагч талын хоорондох сүлжээнд гэмтэл гарсан эсвэл ТВ суваг талаас дуу, дүрсний шаардлага хангахгүй сигнал ирж буй тохиолдолд ТВ суваг нь техникийн хэмжилт шалгалтыг цаг алдалгүй хийж, үүссэн гэмтлийг шуурхай засварлах үүрэгтэй;
 - 3.1.7. ТВ суваг нь техникийн саатал, үзлэг үйлчилгээний улмаас нэвтрүүлэг нийлүүлэхэд тасалдал гарсан бол MNBC TV-ийн засварын инженер Н.Мягмарсүрэнд myagmarsuren@mnbctv.mn хаягаар болон **89340010** утсаар мэдэгднэ;
 - 3.1.8. ТВ суваг нь холболтын цэг хүртэлх сүлжээний найдвартай ажиллагааг хариуцна;

- 3.1.9. ТВ суваг нь үйлчилгээнд нөлөөлхүйц техникийн үзлэг үйлчилгээ хийхээр бол 72 цагийн өмнө мэдэгдэж, гэмтэл гарсан эсвэл техникийн үзлэг хийгдэж байгаа үед хэрэглэгчдэд мэдээлэл бүхий дүрсийг дамжуулна;
- 3.1.10. ТВ суваг тал хаяг, байршил сольсон тохиолдолд шилэн кабел татах, сигнал хүлээн авах тоног төхөөрөмжтэй холбоотой гарах зардлыг 100% хариуцна;
- 3.1.11. ТВ суваг талын Ерөнхий захирал, гүйцэтгэх захирал удирдлагын болон хуулийн этгээд өөрчлөн байгуулах замаар гүйцэтгэх удирдлагад өөрчлөлт орсон тухай бүрт албан бичгээр дамжуулагч талд мэдэгдэх ба мэдэгдсэнээр төлбөрөөс чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.

ДӨРӨВ. ДАМЖУУЛАГЧ ТАЛЫН ЭРХ ҮҮРЭГ

- 4.1. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг ТВ суваг-с шаардах;
- 4.2. Гэрээ болон холбогдох хууль тогтоомжид заасан үүргээ зохих ёсоор биелүүлээгүйн улмаас Дамжуулагч талд учирсан хохирол, түүнийг арилгахад гарсан зардлыг ТВ суваг талаас нэхэмжлэх эрхтэй;
- 4.3. ТВ суваг талын сүлжээг хүлээн авч өөрийн сүлжээгээр дамжуулан хэрэглэгчдэд чанартай хүргэх үүрэгтэй;
- 4.4. Дамжуулагч тал нь өөрийн өмчлөлд хамаарах тоног төхөөрөмж, шилэн кабелийн ашиглалт үйлчилгээг 100% хариуцах бөгөөд түүний найдвартай, аваар осолгүй, ашиглалтын технологийн горимыг ТВ суваг талаас хамааралгүй зохион байгуулж ажиллах үүргийг дангаар хүлээнэ;
- 4.5. Хэрэглэгчдэд очиж байгаа сигналын төвшин, чанарт анхаарал тавьж ажиллах ба ТВ суваг талаас шалтгаалаагүй доголдлыг дангаар хариуцаж арилгана;
- 4.6. Байгалийн гамшиг давтагдашгүй хүчин зүйлийн улмаас үүдэлтэй техникийн саатал болон технологийн онцлогт сөргөөр нөлөөлөх цаг агаарын хүчин зүйлийн улмаас сигналын чанарт өөрчлөлт орвол 3.1.3 дах заалт хамаарахгүй.

ТАВ. ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ

5.1. Холболт хийх техникийн үзүүлэлт

- 5.1.1. Талуудын холболтын болон дамжуулах байгууламжийн төрөл марк, интерфейсүүд, холбогдоход шаардагдах бусад техник төхөөрөмж, багтаамж, тоо ширхэг зэрэг нь Хавсралт 1-ийн дагуу байна. Хавсралт 1-д орсон нэмэлт өөрчлөлтүүдийг тухай бүр бичгээр тусгаж байна.
- 5.1.2. Сүлжээ хоорондын дамжуулах видео сигнал нь SMPTE 292M стандартыг хангасан байх ба энэ нь хэрэглэгчид рүү дуу дүрсний чанар хангасан ТВ-ийн сигнал дамжуулах нөхцөлийг бүрдүүлнэ.
- 5.1.3. Талуудын холболтын шугам нь өндөр хурдны оптик сүлжээ байна.

5.2. Зааглах цэг

- 5.2.1. Сүлжээний зааглах цэгүүдийн байршил болон холболтын схем зураглал нь Хавсралт №2-т заасны дагуу байна.
- 5.2.2. Талууд зааглах цэгээс 2 тийш шугамыг таслан шалгалт, хэмжилт хийх техникийн боломж, нөхцөлийг хангасан байна.

5.3. Сүлжээний ачаалал

- 5.3.1. Талууд өөрсдийн холболтын техникүүд /хувиргах, дамжуулах төхөөрөмжүүд болон сигнал дамжуулах бүх төрлийн кабелиуд/-ийн найдвартай ажиллагаа, бүрэн бүтэн байдлыг ханган ажиллана.
- 5.3.2. ТВ суваг талаас эфирийн гаралтын дуу дүрсний форматаа өөрчлөх (*Техникийн өөрчлөлт болон software update хийх*) тохиолдолд ажлын 10-15 хоногийн өмнө урьдчилан дамжуулагч талд мэдэгдэн харилцан тест хийж талууд сувгийн үйлчилгээний хэвийн ажиллагааг хангах тал дээр хамтран ажиллана.
- 5.3.3. Холболтын гэрээний хугацаанд хийгдэх техник тоног төхөөрөмжийн өргөтгөл, өөрчлөлт нь холбогдогч талуудын үйлчилгээнд нөлөөлөхүйц байвал энэ талаарх мэдээллийг 72

цагаас доошгүй хугацааны өмнө нөгөө талдаа мэдэгдэх ба асуудлыг талууд хамтран шийдвэрлэнэ.

ЗУРГАА. АШИГЛАЛТ ҮЙЛЧИЛГЭЭ

- 6.1. Талууд зааглах цэгээс хоёр тийш өөрсдийн хариуцсан бүсэд гарсан тоног төхөөрөмж, шилэн кабелийн гэмтлийг бүрэн хариуцан өөрсдийн зардлаар засварлана.
- 6.2. Эрчим хүчний найдвартай ажиллагааг талууд өөрсдийн хариуцах талдаа хангана.
- 6.3. Сувгийн холболтын тоног төхөөрөмжид дур мэдэн өөрчлөлт оруулахгүй байх үүрэгтэй.
- 6.4. ТВ суваг нь анх холболт хийсэн хаягаас нүүх тохиолдолд тоног төхөөрөмжийг шилжүүлэх, дахин холбохтой холбогдон гарах зардлыг дангаар хариуцна. Тухайн байршилд 3-аас дээш жил байрлах нөхцөлд тухайн телевизрүү MNBC-ийн шилэн кабелийн холболтыг холбоно. Дээрх хугацаанаас бага хугацаанд байрлах нөхцөлд тухайн холболтын тодорхой хувийг буцааж төлнө.
- 6.5. Талууд үйлчилгээний чанар нь стандарт түвшинд хэвийн ажиллаж байгаа эсэхэд хяналт тавих бөгөөд ТВ сувгийн үйлчилгээний чанар нь стандарт түвшинд хүрэхгүй бол тухай бүр Хавсралт-3-т заасан ажилтанд холбогдох мэдээллийг хүргэж шуурхай арга хэмжээ авч хамтран ажиллана.
- 6.6. Талууд аливаа гэмтэл саатал гарсан үед Хавсралт 3-д заасан холбогдох мэдээллийг хүргэх бөгөөд үүссэн гэмтэл сааталд хамаарах тал нь шуурхай арга хэмжээ авч засварлан ажиллана.
- 6.7. Үйлчилгээний системд өөрчлөлт шинэчлэлт оруулах, Техникийн зайлшгүй шалтгааны улмаас түр хугацаанд систем дээр төлөвлөгөөт ажил хийхээр бол Хавсралт 3-д заасны дагуу мэдээллийг хүргэж ажиллана.
- 6.8. ТВ суваг нь 1 сараас дээш хугацаанд эфирээ өгөөгүй тохиолдолд дамжуулагч нь ТВ рүү анхааруулсан мэдэгдэл хүргүүлэх бөгөөд ТВ суваг нь мэдэгдэл хүлээн авснаас хойш 2 сарын хугацаанд эфирээ өгөөгүй нөхцөлд сувгийг хаах ба дамжуулагч нь тухайн сувгийн дугаарлалтыг хадгалах үүрэг хүлээхгүй
- 6.9. Талууд холболтын найдвартай байдлыг хангаж, гадны халдлагаас хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллана.

ДОЛОО. ТӨЛБӨР ТООЦОО

- 7.1 Талууд харилцан тохиролцож шилэн кабелийн эсвэл урсгал түрээсийн төлбөрийн хэмжээг хавсралтаар тусгайлан тогтооно.
- 7.2 Холболтын зардалтай холбоотой төлбөр тооцоог энэхүү гэрээний Хавсралт 4-т тусгасан дүнгийн дагуу тооцно.
- 7.3 ТВ суваг нь холболтын зардлыг гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш ажлын 5 хоногийн дотор дамжуулагчийн **ХААН банк дахь 5028220815** тоот төгрөгийн дансанд шилжүүлнэ.
- 7.4 ТВ суваг нь энэхүү гэрээний зүйлийн 7.2-д заасан хугацаанд холболтын зардлыг шилжүүлээгүй бол дамжуулагч тал холболтын үйл ажиллагааг хийхгүй байх эрхтэй. Дамжуулагч ийнхүү холболтын үйлчилгээг үзүүлээгүй нь гэрээний зөрчилд тооцох үндэслэл болохгүй.

НАЙМ. ХҮСЭЛТ ГАРГАХ, ТҮҮНИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

- 8.1. Талууд нь өөрийн сүлжээнд холбогдох техникийн нөхцөл, холболтын зардал, сүлжээнд холбогдон үзүүлэх гэж буй үйлчилгээний талаарх бизнесийн нууц бус мэдээллийг албан ёсоор хүсэлт гаргаснаас хойш ажлын 10 хоногийн дотор хүссэн талд гаргаж өгөх ба мэдээллийг өрсөлдөөний эсрэг ашиглахыг хориглоно.
- 8.2. Талууд өөрийн сүлжээнд холбогдох боломжийг тухай бүрт нь аль болох шуурхай бүрдүүлэх ба тухайн үед техникийн нөхцөл гаргах боломжгүй байсан тохиолдолд уг нөхцөлийг бүрдүүлэх боломжтой хугацааг мэдэгдэнэ.
- 8.3. Талууд мэдээллээ албан бичгээр харилцан солилцоно.

ЕС. ХАРИУЦЛАГА

- 9.1. Аль нэг тал нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэхгүй байх эсхүл зөрчсөн тохиолдолд энэхүү гэрээгээр, мөн Монгол Улсын холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээх бөгөөд нөгөө талд учирсан хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй.
- 9.2. Талууд энэхүү гэрээний хүрээнд олж авсан төрийн болон байгууллага, хувь хүний нууцад хамаарах аливаа мэдээллийг чандлан хадгалах, хамгаалах үүргийг хугацаагүй хүлээх ба эрх бүхий байгууллагаас шаардсанаас бусад тохиолдолд тухайн нууц мэдээллийг задруулах, бусдад дамжуулах, нийгэд ил болгохыг хориглоно.
- 9.3. Аль нэг тал нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх, эсхүл удаа дараа зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд нөгөө тал үүргийн гүйцэтгэлийг хангах дор дурьдсан аргыг шат дараатайгаар хэрэглэнэ:
- 9.4. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх талаар хугацаа тогтоосон мэдэгдэл хүргүүлэх;
- 9.5. Холболтын зардлыг гэрээнд заасан хугацаанаас хэтрүүлсэн тохиолдолд холболтын хязгаарлалт, салгалтыг хийх.
- 9.6. Энэхүү гэрээний дагуу төлбөр төлөх хугацааг хэтрүүлсэн тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд төлбөл зохих үнийн дүнгийн 0,3 хувьтай тэнцүү алданги тооцно.
- 9.7. Энэхүү гэрээний 9.6-д заасан арга хэмжээг хүлээсэн нь талуудыг гэрээний үүргээ биелүүлэхгүй байх болон учирсан хохирлыг нөхөн төлөхөөс чөлөөлөх үндэслэл болохгүй.
- 9.8. Учирсан хохирол гэдэгт аль нэг талаас гэрээний үүргээ биелүүлээгүй эсвэл зохих ёсоор биелүүлээгүйн улмаас нөгөө талаас гарсан зардал, эд хөрөнгийн алдагдал буюу гэмтэл, гэм буруутай тал гэрээнд заасан үүргээ гүйцэтгэсэн бол нөгөө талд учрахгүй байсан зарлага зэргийг тооцно.

АРВ. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

- 10.1. Энэ гэрээтэй холбогдон үүсч болох аливаа маргаан, санал зөрөлдөөнийг Талууд зөвшилцлийн журмаар шийдвэрлэхийг оролдох бөгөөд зөвшилцөлд хүрээгүй тохиолдолд маргаан, санал зөрөлдөөнийг ХХЗХ-нд хандаж шийдвэрлүүлнэ.
- 10.2. Холбогдох хууль, журмын хүрээнд ХХЗХ-оос гаргасан шийдвэрийг маргалдагч Талууд аль болох хүлээж авна. Хэрэв ХХЗХ-ны шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй бол Талууд шүүхэд хандаж шийдвэрлүүлнэ.

АРВАН НЭГ. ГЭРЭЭНИЙ ҮЙЛЧЛЭХ ХУГАЦАА

- 11.1. Энэхүү гэрээнд Талуудын эрх бүхий төлөөлөгчид энэхүү гэрээнд гарын үсэг зурж, тамга даран баталгаажуулсанаар хүчин төгөлдөр болно.
- 11.2. Гэрээг 3 хувь үйлдэх бөгөөд талууд тус бүр 1 хувийг хадгалж, ХХЗХ-нд 1 хувийг хүргүүлнэ.
- 11.3. Гэрээний хугацаа дуусгавар болсноор, мөн гэрээ цуцлагдснаар гэрээний үүргийн зөрчилтэй холбоотой шаардах эрхээс бусад талуудад олгогдсон эрх, үүрэг мөн адил дуусгавар болно.

АРВАН ХОЁР. ГЭНЭТИЙН БОЛОН ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

- 12.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл гэдгийг Монголын худалдаа аж үйлдвэрийн танхимаас гэрчилсэн тохиолдолд давагдашгүй хүчин зүйл гэж үзнэ.
- 12.2. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлсийн улмаас Талуудын аль нэг нь гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй бол нөгөө талдаа ажлын 3 /гурав/ хоногийн дотор бичгээр мэдэгдэх ба энэ тохиолдолд үүрэг гүйцэтгэх хугацаа нь энэхүү нөхцөл байдал үргэлжлэх хугацаагаар хойшлогдоно.
- 12.3. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлс бий болсон нь хуанлийн нэг сараас дээш хугацаагаар үргэлжилбэл Талууд асуудлыг харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.
- 12.4. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл гэдэгт гал түймэр, газар хөдлөлт, салхи шуурга, аянга цахилгаан, үер усны гамшиг зэрэг байгалийн гамшиг, нийтийг хамарсан үймээн самуун, эмх замбараагүй байдал, ажил хаялт, эрчим хүчний тасалдал, сүлжээний хэт ачаалал, гуравдагч этгээдийн буруугаас сүлжээний үйлчилгээ тасалдах, эсэргүүцлийн хөдөлгөөн, гоц халдварт

өвчин, дайн, террорист халдлага, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр, хорио, цээр зэрэг талуудын хүсэл зоригоос үл хамаарах шалтгаануудыг ойлгоно.

- 12.5. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлсийн улмаас Талууд гэрээний үүргээ биелүүлээгүй эсвэл зохих ёсоор биелүүлээгүй бол хариуцлага хүлээхгүй болно.
- 12.6. Гамшгаас хамгаалах хуульд заасны дагуу давагдашгүй хүчин зүйл дохиолдсон үед эрх бүхий байгууллагаас үүрэг болгосон тохиолдолд нэвтрүүлгийн дундуур цаг үеийн мэдээг шуурхай хүргэх .

АРВАН ГУРАВ. БУСАД

- 13.1. Талууд харилцан хэвийн үйл ажиллагаагаа явуулах нөхцөлийг алдагдуулах аливаа үйл ажиллагаа явуулахгүй.
- 13.2. Энэхүү гэрээнд шууд заагаагүй аливаа асуудлыг Монгол Улсын дагаж мөрдөж буй хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.
- 13.3. Энэхүү гэрээнд Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр бичгээр үйлдсэн гэрээний хэлбэрээр нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд эх хувьд засварласан буюу бусад аргаар оруулсан аливаа нэмэлт өөрчлөлтийг хүчингүйд тооцно.
- 13.4. Талуудын аль нэг нь энэхүү гэрээг хугацаанаас нь өмнө цуцлахыг хүсвэл энэ тухай хүсэлтээ нөгөө талдаа 1/нэг/ сараас доошгүй хугацааны өмнө албан бичгээр мэдэгдэх ба нөгөө Тал зөвшөөрснөөр гэрээг дуусгавар болсонд тооцно.
- 13.5. Талууд гэрээнд гарын үсэг зурсан өдрөөс хойш 10 хоногийн дотор гэрээг хавсралтуудын хамт ХХЗХ-нд хүргүүлэх ба нэмэлт, өөрчлөлтийг тухай бүр ХХЗХ-нд хүргүүлнэ.
- 13.6. Талуудын төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх захирал, өмчлөгч өөрчлөгдсөнөөс үл хамааран энэхүү гэрээний 1.6-д заасан хугацаанд гэрээ хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 13.7. Аль нэг тал энэ гэрээтэй холбоотойгоор нөгөө талын бизнесийн хэвийн үйл ажиллагаагаа явуулах нөхцөлийг алдагдуулах аливаа үйл ажиллагаа явуулахгүй бөгөөд энэхүү заалтыг зөрчсөнөөс үүсэх үр дагаварыг нөгөө талын өмнө бүрэн хариуцна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Талууд энэхүү гэрээнд заасан бүхий л нөхцөл, заалтуудыг хүлээн зөвшөөрч байгаа болон тухайн компанийг төлөөлөн гэрээ байгуулах бүрэн эрхтэй албан тушаалтан мөн болохоо нотлон доор гарын үсэг зурж, баталгаажуулав.

ДАМЖУУЛАГЧИЙГ төлөөлж:

ТВ СУВАГ-Г төлөөлж:

ЭН БИ СИ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

С.ЭРХЭМБАТ

МЭДЭЭЛЭЛ ТЕХНИК ТЕХНОЛОГИЙН
ГАЗРЫН ЗАХИРАЛ

Д.ОЮУНГЭРЭЛ

САНХҮҮ БҮРТГЭЛИЙН ГАЗРЫН ЗАХИРАЛ

Г.ТҮМЭНЖАРГАЛ

ГЭРЭЭ ЭРХ ЗҮЙН МЕНЕЖЕР

*ЭН БИ СИ ХХК болон..... ХХК-ийн
холболтын..... тоот гэрээний Хавсралт 1*

ХОЛБОЛТ ХИЙХ ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Үзүүлэлт	ТВ суваг	ЭН БИ СИ
Холболтын төхөөрөмжийн төрөл, марк	Playout server	Encoder
Инкодер /хөрвүүлэх төхөөрөмж/ -ийн төрөл, марк	3G /HD/SD – SDI fiber Transmitter	3G/HG/SD- SDI fiber receiver
Гаралтын формат	I core fiber optic cable	I core fiber optical
Интерфейсийн төрөл	3G /HD/ SD- SDI	3G/HG/SD-SDI


Техникийн үзүүлэлт, холболтын стандартыг дамжуулагч тал тухай бүр тодорхойлно.

ТВ суваг нь Телевизийн студи-Тоног төхөөрөмжид тавих ерөнхий шаардлага MNS 5592-2:2016 стандартыг дагаж мөрдөнө.

ТВ СУВАГ БОЛОН ЭН БИ СИ СҮЛЖЭЭ ХООРОНДЫН
ХОЛБОЛТЫН ЗААГЛАХ ЦЭГ, ЗУРАГЛАЛ

Хамрах хүрээ: Улаанбаатар хотод

1. Телевиз нь MNBC-ийн кабелиар шууд холбогдох үед зааглах цэгийн байрлал



ХАВСРАЛТ БАТАЛСАН:

ДАМЖУУЛАГЧИЙГ төлөөлж:

ТВ СУВАГ-Г төлөөлж:

МЭДЭЭЛЭЛ ТЕХНИК ТЕХНОЛОГИЙН
ГАЗРЫН ЗАХИРАЛ

Д.ОЮУНГЭРЭЛ

САНХҮҮ БҮРТГЭЛИЙН ГАЗРЫН ЗАХИРАЛ

Г.ТҮМЭНЖАРГАЛ

ХАРИЛЦАН МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ АЛБАН ТУШААЛТАН,
ТЭДГЭЭРИЙН НЭРС, ХОЛБОО БАРИХ АРГА ХЭРЭГСЭЛ

ТВ СУВГИЙН албан тушаалтан, холбоо барих арга хэрэгсэл:

	Алба, хэлтэс	Албан тушаалтан	Холбоо барих хэрэгсэл
Техникийн асуудлаар	ТТГазар	М.Идэржавхлан	91997211
		Эфирийн инженерүүд	77110001
Төлбөр тооцооны асуудлаар	БМГазар	Захирал Г.Ган-Эрдэнэ	99087143
Хөтөлбөртэй холбоотой асуудлаар	Программ төлөвлөлтийн газар	Б.Эрхэмбилэг	88002537

ДАМЖУУЛАГЧИЙН –ийн албан тушаалтан, холбоо барих арга хэрэгсэл:

	Алба, хэлтэс	Овог нэр Албан тушаалтан	Холбоо барих хэрэгсэл
Гэрээний асуудлаар	БТГазар	Захирал Г.Гарьдхүү	99054045
	ЗУГазар	Захирал Х.Мөнхзул	99121484
Техникийн асуудлаар	МТТГазар	МТТГ захирал Д.Оюунгэрэл	Утас: 89114805 И-мэйл: oyungerel@mnbctv.mn
		Инженер Н.Мягмарсүрэн	Утас: 99784345 И-мэйл: MNBC_epg@yahoo.com
Төлбөр тооцооны асуудлаар	Санхүү бүртгэлийн газар	Тооцооны нягтлан бодогч Б.Алтанноров	Утас: 80079907 И-мэйл: altannorov@mnbctv.mn
		Төлбөр тооцоо хариуцсан ажилтан Б.Энхзаяа	Утас: 98100922 И-мэйл: enkhzaya@mnbctv.mn

ХАВСРАЛТ БАТАЛСАН:

ДАМЖУУЛАГЧИЙГ төлөөлж:

ТВ СУВАГ-Г төлөөлж:

МЭДЭЭЛЭЛ ТЕХНИК ТЕХНОЛОГИЙН
ГАЗРЫН ЗАХИРАЛ

Д.ОЮУНГЭРЭЛ

САНХҮҮ БҮРТГЭЛИЙН ГАЗРЫН ЗАХИРАЛ

Г.ТҮМЭНЖАРГАЛ

**DVB-T2 СТАНДАРТ БУЮУ ГАЗРЫН ДАМЖУУЛАЛТЫН
СҮЛЖЭЭНИЙ ҮЙЛЧИЛГЭЭНД СУВАГ ХОЛБОХ ХОЛБОЛТ, ДАМЖУУЛАЛТЫН ЗАРДАЛ**

1. Телевизийн суваг дамжуулах сарын хураамжийн задаргаа /сар бүр/

Зардлын төрөл	Зааглах цэгийн байршил
	I дүгээр нөхцөл
Шилэн кабелийн эсвэл урсгал түрээсийн төлбөр₮

Дээрх үнэд НӨАТ багтаагүй болно.

Тайлбар:

“Сүлжээ хооронд харилцан холболт хийх, сүлжээнд холбогдох гэрээний ерөнхий нөхцөл, орлого хуваарилах журам”-ын 2.9-д зааснаар дээрх төлбөрийн хэмжээг тогтоохдоо бизнесийн аливаа алдагдлыг нөхөх зорилго агуулахгүй байх зарчмыг баримтлана.

ХАВСРАЛТ БАТАЛСАН:

ДАМЖУУЛАГЧИЙГ төлөөлж:

ТВ СУВАГ-Г төлөөлж:

МЭДЭЭЛЭЛ ТЕХНИК ТЕХНОЛОГИЙН
ГАЗРЫН ЗАХИРАЛ

Д.ОЮУНГЭРЭЛ

САНХҮҮ БҮРТГЭЛИЙН ГАЗРЫН ЗАХИРАЛ

Г.ТҮМЭНЖАРГАЛ

ХӨТӨЛБӨР ДАМЖУУЛАХ НӨХЦӨЛ

НЭГ. НИЙТЛЭГ ЗҮЙЛ

- 1.1. Дамжуулагч нь MNBC сүлжээгээр /DVB-T2 стандарт буюу газрын дамжуулалтын сүлжээ/ “.....” сувгийг SD/HD форматаар чанарын өндөр түвшинд дамжуулна.
- 1.2. Энэхүү нөхцөлд заагаагүй бусад зүйлийг тоот Холболтын гэрээгээр зохицуулна.

ХОЁР. ХӨТӨЛБӨР ДАМЖУУЛАХТАЙ ХОЛБООТОЙ ЗОХИЦУУЛАЛТ

- 2.1. Энэхүү гэрээний 1.1-д заасантай холбогдон үүсэх хамтын ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд Талууд дараах ерөнхий эрх, үүргийг харилцан адил хэрэгжүүлнэ. Үүнд:
 - 2.1.1. Энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх үүрэгтэй.
 - 2.1.2. Энэхүү гэрээнд заасны дагуу үүргийн гүйцэтгэлийг хангах аргуудыг хэрэглэх эрхтэй.
 - 2.1.3. Энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэх үүрэгтэй, нөгөө талаасаа биелүүлэхийг шаардах эрхтэй.
 - 2.1.4. Энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд хариуцлага хүлээх үүрэгтэй.
 - 2.1.5. Энэхүү гэрээг байгуулах болон хэрэгжүүлэх явцад албан болон албан бусаар мэдсэн хуулийн этгээдийн нууцыг хуулийн дагуу хадгалах үүрэгтэй.
 - 2.1.6. Аль нэг тал нь өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас нөгөө талд учруулсан хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй.
 - 2.1.7. Энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй байх үүрэгтэй.

ГУРАВ. КОНТЕНТТОЙ ХОЛБООТОЙ ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

- 3.1. Дамжуулагч дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:
 - 3.1.1. Дамжуулагч нь ТВ сувгийн дамжуулагдах эфирт өөрчлөлт оруулахгүй, нэмэлт лого, титр байршуулахгүй, хөндлөнгөөс эфирт ямар нэг байдлаар нөлөөлөхгүй мөн нэвтүүлгийн хөтөлбөрийг хууль бус үйлдлээс бусад тохиолдолд таслахгүй байх үүрэгтэй.
 - 3.1.2. ТВ сувгаас хамаарсан гэмтэл, саатлын улмаас эфирийг тасалдуулсан тохиолдолд дамжуулагч нь энэ талаар хэрэглэгчдэд мэдээлэл хүргэх эрхтэй.
 - 3.1.3. ТВ сувгийн эфирээр цацагдаж буй мэдээ, мэдээлэл болон контентын өмнө дамжуулагч ямарваа нэгэн хариуцлага хүлээх үүрэг хүлээхгүй.
 - 3.1.4. ТВ сувгийн эфирээр цацагдаж буй мэдээ, мэдээлэл болон контентын агуулга, бодлогод хөндлөнгөөс үл нөлөөлөх үүрэгтэй.
- 3.2. ТВ суваг дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:
 - 3.2.1. ТВ суваг нь өөрийн эфирээр цацагдаж буй мэдээ, мэдээлэл болон контентын агуулга, бодлогыг бие даан тодорхойлох эрхтэй.
 - 3.2.2. ТВ суваг нь өөрийн эфир, контентын дамжуулалтын дуу дүрсний чанар, стандартад хяналт тавьж Дамжуулагчид шаардлага тавих эрхтэй бөгөөд өөрийн нэвтрүүлгийн хөтөлбөр, контент тэдгээртэй холбоотой хууль ёсны эрхийн зөвшөөрөл болон бусад холбогдон үүсэх хариуцлагыг хүлээх үүрэгтэй.
 - 3.2.3. ТВ суваг нь 24 цагаар эфирээ таслахгүй байх, эфирийн дуу, дүрсний чанар стандартыг хангах үүрэгтэй.
 - 3.2.4. ТВ суваг нь өөрийн эфирийг дамжуулахад ашиглаж буй тоног төхөөрөмжийн ашиглалт үйлчилгээний зардлыг гэрээний хугацаанд хариуцна.

ДӨРӨВ. ТЕЛЕВИЗИЙН ХӨТӨЛБӨРТЭЙ ХОЛБООТОЙ ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

- 4.1 Дамжуулагч нь дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:**
- 4.1.1 ТВ суваг нь гэрээний Хавсралт 6-д заасан форматын дагуу хөтөлбөрөө өгөөгүйгээс үүссэн хөтөлбөрийн мэдээлэлтэй холбоотой ямарваа нэгэн гомдлыг Дамжуулагч хариуцахгүй.
 - 4.1.2 Дамжуулагч нь ТВ сувгийн ирүүлсэн хөтөлбөрийн дарааллыг дур мэдэн зөрүүлэх, өөрчлөхгүй байх үүрэгтэй.
 - 4.1.3 ТВ суваг нь урьдчилан мэдэгдэлгүйгээр телевизийн хөтөлбөрийг зөрүүлсэн, өөрчлөлт оруулсан, эфирээ тасалсаны улмаас ямарваа нэгэн маргаан үүссэн тохиолдолд хэрэглэгчдэд шаардлагатай бол албан ёсоор мэдэгдэл хийж болно.
 - 4.1.4 ТВ сувгийн нэвтрүүлгийн хөтөлбөрийг Дамжуулагч зөрүүлсэн, өөрчлөлт оруулсанаас ямарваа нэгэн маргаан үүссэн тохиолдолд хэрэглэгчдэд шаардлагатай бол албан ёсоор мэдэгдэл хийж болно.
- 4.2 ТВ суваг дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:**
- 4.2.1 ТВ суваг нь 7 хоног бүрийн баасан гарагийн 17:00 цагаас өмнө дараагийн 7 хоногт дамжуулах нэвтрүүлгийн хөтөлбөрөө MNBC_epg@yahoo.com имэйл хаягт тогтмол ирүүлж байна. ТВ суваг энэхүү гэрээний Хавсралт 2-ийн дагуу дамжуулагчид хүргүүлсэн нэвтрүүлгийн хөтөлбөрт дангаараа ямар нэгэн өөрчлөлт оруулахгүй байх үүрэгтэй. Хөтөлбөрт өөрчлөлт орсон тохиолдолд 24 цагийн өмнө MNBC_epg@yahoo.com хаягаар болон **89340010** утсанд 24 цагийн өмнө мэдэгдэнэ.
 - 4.2.2 ТВ суваг нь нэвтрүүлгийн хөтөлбөрийг гэрээний Хавсралт 6-д заасан форматын дагуу үг үсгийн алдаагүй, тайлбар, онцлох нэвтрүүлэгийн мэдээлэлтэй хүргүүлнэ.
 - 4.2.3 Дамжуулагч урьдчилан мэдэгдэлгүйгээр телевизийн хөтөлбөрийг зөрүүлсэн, өөрчлөлт оруулсан, эфирээ тасалсаны улмаас үүсэх аливаа гомдол, маргаан үүссэн тохиолдолд ТВ суваг өөрийн эфирээр албан ёсоор мэдэгдэл хийх, дамжуулагчаар дэлгэцэнд мэдэгдэл гаргуулах үүрэгтэй.

ТАВ. ТАЛУУДЫН ХАРИУЦЛАГА

- 5.1. ТВ суваг тал нь өөрийн сувгаар дамжуулж байгаа бэлтгэсэн нэвтрүүлэг, кино контент , контентийн нийтэд түгээх эрхийг дамжуулагч талд олгож байгаа бөгөөд бэлтгэсэн нэвтрүүлэг, кино контент , контент нь Монгол улсын хууль, дүрэм, хориглосон үйл ажиллагаанд нийцэж буй эсэх талаар ямар нэгэн хариуцлагыг дамжуулагч тал хүлээхгүй.
- 5.2. Дамжуулагч нь Зохиогчийн эрхийг хамгаалах тухай хуульд заасны дагуу өөрийн болон бусад сервер, сүлжээ, санд зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн зөрчил гаргахгүй байх, зохиогчийн эрх болон хамаарах эрх эзэмшигчийг эрхээ хэрэгжүүлэх боломжоор хангах үүрэгтэй.
- 5.3. Дамжуулагч нь зохиогчийн эрх болон хамаарах эрх эзэмшигчийн эрх зөрчигдөж байгаа тухай мэдээллийг хүлээн авах нөхцөлийг бүрдүүлэх, зөрчлийн тухай мэдсэн даруй тухайн зөрчилтэй бүтээл, хамаарах эрхийн объект ашиглалтыг зогсоох, хаах үүрэг хүлээнэ.
- 5.4. ТВ суваг нь Зохиогчийн эрх, түүнд хамаарах эрхийн тухай хуулийг зөрчсөн, дуу дүрсний чанар болон техникийн стандартыг хангаагүй, хөтөлбөрийн цаг баримтлаагүй, төлбөр төлөөгүй, гэрээний хугацаа дууссан, тусгай зөвшөөрлийн хугацаа дуусан, гэрээний үүргээ удаа дараа биелүүлээгүй тохиолдолд дамжуулагч сувгийн дугаарлалтыг өөрчлөх эрхтэй.
- 5.5. Аль нэг тал нь өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас /санаатай болон болгоомжгүй үйлдэл, технологийн горимын ямарваа нэгэн зөрчил г.м/ нөгөө талдаа хохирол учруулбал хамтарсан техникийн комиссын шийдвэрийг үндэслэн хохирлыг буруутай тал төлж барагдуулна.

ЗУРГАА. БУСАД

- 6.1. Энэхүү гэрээ нь талуудын байгуулсан тоот Холболтын гэрээний салшгүй хэсэг байх ба үндсэн гэрээний хугацаанд хүчинтэй байна.

НӨХЦӨЛИЙГ БАТАЛСАН:

ДАМЖУУЛАГЧИЙГ төлөөлж:

ТВ СУВАГ-Г төлөөлж:

БИЗНЕС ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН
ЗАХИРАЛ

Г.ГАРЬДХҮҮ

САНХҮҮ БҮРТГЭЛИЙН ГАЗРЫН ЗАХИРАЛ

Г.ТҮМЭНЖАРГАЛ

*Эн Би Си ХХК болон ХХК хооронд
байгуулсан _____ тоот гэрээний Хавсралт 6*

“.....” СУВГИЙН 7 ХОНОГИЙН ХӨТӨЛБӨР

Гэрээний 4.2.2-т заасны дагуу Нэвтрүүлгийн хөтөлбөрийг дараах зааврын дагуу бэлтгэнэ.

1. Нэвтрүүлэг, контент, хөтөлбөрийн нэрийг нэг хүснэгтэд 30 тэмдэгтэд багтаан шивж ирүүлэх; /30 тэмдэгтээс хэтэрвэл үндсэн болон туслах цэсүүдэд үлдсэн хэсэг нь харагдахгүйг анхаарна уу/
2. Нэвтрүүлэг, хөтөлбөрийн нэрийн бүх тэмдэгт ТОМ үсгийн фондоор шивж ирүүлэх;
3. Өдөр бүрийн эфирийн төгсгөлд заавал “Эфир завсарлага”, “Эфир хаасан” эсвэл “Эфир завсарласан” гэсэн текст бичиж тавих;

ХӨТӨЛБӨР БИЧИХ ХҮСНЭГТИЙН ЗАГВАР

202.... ОНЫ-Р САРЫН-НЫ ГАРАГ		
ЭХЛЭХ	ДУУСАХ	НЭВТРҮҮЛГИЙН НЭР
06:00	06:45	“.....” МЭДЭЭЛЛИЙН ХӨТӨЛБӨР
06:45	07:00	“.....” СПОРТЫН МЭДЭЭ
07:00	07:15	ХӨГЖМИЙН ЗАВСАРЛАГА
07:15	08:00

ХӨТӨЛБӨР ГАРГАСАН:

“.....” СУВГИЙНАЖИЛТАЙ/.....НЭР..... /

